

БАТЛАВ.
“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

БАТЛАВ.
“БАТ ГАЗ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц. ЭНХТҮВШИН

Д. БАЯРСАЙХАН

ОРООМГИЙН БОЛОН ЦАХИЛГААНЫ УТАС ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ
/ШО/202301027/

2023 он 03 сарын 30 өдөр

№.

Шивээговь сум

Нэг талаас Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд байрлах 2004879 регистрийн дугаартай “Шивээ Овоо” ХК (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж Худалдаа Хангамжийн албаны дарга Б.Чинбэлэг, нөгөө талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, “НИММ аудит” ХХК-ийн байрны 303 тоотод байрлах 6006418 регистрийн дугаартай “Бат газ” ХХК (цаашид “Нийлүүлэгч” гэх) түүнийг төлөөлж захирал Д. Баярсайхан нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29-р зүйл, Иргэний хуулийн 243-268-р зүйлийг удирдлага болгон дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож энэхүү “Ороомгийн болон цахилгааны утас худалдан авах” (цаашид “Гэрээ” гэх) гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий нөхцөл

- 1.1 Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь Захиалагчид захиалгын дагуу хавсралт №01-д заасан биет байдлын болон эрхийн доголдолгүй Олон Улс болон Монгол улсын чанар стандартын шаардлагад нийцсэн Ороомгийн болон цахилгааны утас (цаашид “Бараа” гэх) түүнтэй холбоотой баримт бичгийг захиалагчийн өмчлөлд шилжүүлэх ба захиалагч нь барааг хүлээн авч гэрээнд заасан хугацаанд төлбөр барагдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хуулиар зохицуулна.
- 1.3 Талуудын аль нэг хуулийн этгээдийн хувьд өөрчлөн байгуулагдсан нь энэхүү гэрээг цуцлах болон үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.
- 1.4 Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээ нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд **2023 оны 12 дугаар сарын 31-ны өдөр** хүртэл хүчинтэй байна.
- 2.2 Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал бичгээр харилцан тохиролцож сунгаж болно.
- 2.3 Энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө дараах үндэслэлүүдээр цуцалж болно. Үүнд:
 - 2.3.1 Гэрээгээр тогтоосон хугацааны дотор захиалагч төлбөрөө төлөөгүй нөхцөлд, түүнчлэн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нийлүүлэлт хийх боломжгүй болсон тухайгаа захиалагчид албан ёсоор бичгээр мэдэгдсэн тохиолдолд нийлүүлэгчийн санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцалж болно.

- 2.3.2 Захиалагч нь барааг үргэлжлүүлэн худалдан авахаас татгалзсан тухайгаа нийлүүлэгчид албан ёсоор бичгээр мэдэгдэж тооцоо нийлэн нийлүүлэгдсэн барааны төлбөр болон торгуулиа бүрэн төлж барагдуулсан тохиолдолд мөн гэрээгээр тохиролцсон хугацаанд хавсралтад заасан барааг нийлүүлээгүй тохиолдолд захиалагчийн санаачилгаар хугацаанаас нь өмнө цуцалж болно.
- 2.3.3 Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод зааснаас өөр чанар стандартын шаардлага хангахгүй бараа нийлүүлсэн тохиолдолд захиалагчийн санаачилгаар гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
- 2.3.4 Монгол улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр
- 2.3.5 Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр
- 2.4 Энэхүү гэрээний хүчин төгөлдөр хугацаа дуусмагц талууд үргэлжлүүлэн гэрээний хугацааг сунгах сонирхолтой бол ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34.1.4-д заасан хугацаанд хамтран гэрээг дүгнэсэн акт үйлдэж, гэрээний үйлчлэх хугацааг шинэчлэн тогтоон гэрээний хавсралт үйлдэн харилцан гарын үсэг зурж, баталгаажуулан энэхүү гэрээнд хавсаргаж болно.

Гурав. Үнэ

- 3.1 Гэрээний нийт үнэ [67 104 400] (*Жаран долоон сая нэг зуун дөрвөн мянга дөрвөн зуу*) төгрөг болно.
- 3.2 Гэрээний валют [*төгрөг*] байна.
- 3.3 Гэрээний нийт үнэд [*НӨАТ орсон*] болно.
- 3.4 Барааны үнэд барааг “Шивээ Овоо” ХК-ийн уурхайн үйлдвэрлэлийн талбай дахь сэлбэгийн агуулахад хүргэх тээврийн зардал [*орсон*] болно.
- 3.5 Гэрээний үнэ нь гэрээний хүчинтэй байх хугацаанд тохируулгагүй тогтмол байна.

Дөрөв. Нийлүүлэх хугацаа

- 4.1 Нийлүүлэгч нь захиалагчид нийлүүлэх сэлбэг, материалыг “Шивээ Овоо” ХК-ийн уурхайн үйлдвэрлэлийн талбай дахь сэлбэгийн агуулахад хуанлийн 30 хоногийн дотор нийлүүлнэ.
- 4.2 Гэрээний ерөнхий нөхцөлийн 16.1-д заасны дагуу тендэрт ирүүлсэн нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. Нийлүүлэгч нь нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд барааг нийлүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.
- 4.3 Нийлүүлэгдэх барааны ачилтын мэдээг тухай бүр захиалагчид мэдэгдэнэ.

Тав. Чанарын баталгаа

- 5.1 Энэхүү гэрээний дагуу захиалагчид нийлүүлэгдэх бараа нь чанар стандартын болон техникийн нөхцөлд нийцсэн, түүнд тавигдах шаардлагыг хангасан байна.
- 5.2 Баталгаат хугацаа нь 6 сар байна. Баталгаат хугацаа нь барааг ашиглаж эхэлснээс хойш тооцогдоно.
- 5.3 Нийлүүлэгч нь захиалагчид барааны чанарын баримт бичиг /чанарын сертификат, /-ийг барааны хамт ирүүлнэ.
- 5.4 Захиалагч гэрээний дагуу ирсэн барааг шалгаж авна. Нийлүүлэгдсэн бараа нь шалгах болон ашиглах явцад илэрсэн доголдлыг нийлүүлэгчид доголдол илэрсэн өдрөөс хойш хуанлийн 7 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 5.5 Барааг дагалдан ирэх паспорт, чанарын тодорхойлолт, баталгааны гэрчилгээ болон бусад шаардлагатай баримт бичгийг барааны хамт захиалагчид шилжүүлэн өгнө.
- 5.6 Чанарын барьцаа нь гэрээний үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү байна.

Зургаа. Төлбөр тооцоо

- 6.1 Захиалагч нь урьдчилгаа төлбөргүй болно.
- 6.2 Төлбөрийг дансаар шилжүүлэх ба төлбөр төлөх мөнгөний нэгж нь [**төгрөг**] байна.

- 6.3 Захиалагч нь барааг 100% шалгаж хүлээн авч акт үйлдсэнээс хойш 1-12 сарын дотор нийлүүлэгдсэн барааны төлбөрийг шилжүүлнэ.
- 6.4 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Захиалагч нь гэрээний үнийн дүнгээс чанарын барьцааг суутган үлдэгдэл төлбөр тооцоог хийнэ.

Долоо. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

- 7.1 Нийлүүлэгч нь захиалагчаас нийлүүлсэн барааны үнэ, болон алдангийг нэхэмжлэх эрхтэй.
- 7.2 Чанарын доголдолгүй эд материалыг Захиалагчийн уурхайн үйлдвэрлэлийн талбайн агуулахад, тогтоосон хугацаанд нийлүүлэх үүрэгтэй.
- 7.3 Нийлүүлэгч нийлүүлсэн бараа нь ашиглалтын явцад ашиглалтын норм хугацаанд хүрэлгүй шаардлага хангахгүй болсон тухай мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой барааг үнэ төлбөргүй 14-21 хоногийн дотор шинээр сольж нийлүүлнэ.
- 7.4 Нийлүүлэгч нь Захиалагч талд барааг хүлээлгэн өгөх хүртэлх бүх эрсдэлийг бүрэн хариуцна.
- 7.5 Нийлүүлэгч нь барааг дагалдан ирэх паспорт, чанарын тодорхойлолт, баталгааны гэрчилгээ, бусад шаардлагатай баримт бичгийн хамт барааг хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 7.6 Гэрээ байгуулснаар өөрт ил болсон захиалагч талын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар задруулахгүй байх, хортойгоор ашиглахгүй байх үүрэгтэй.
- 7.7 Нийлүүлэгч тал бараа нийлүүлэлт тасалдах тохиолдолд ажлын 7 /долоо/ өдрийн өмнө энэ тухайгаа бичгээр худалдан авагч талд мэдэгдсэн бол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Найм. Захиалагчийн эрх, үүрэг

- 8.1 Захиалагч нь нийлүүлэгчээс өөрийн техник, хэрэгслийн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц чанар, стандартын шаардлага хангасан барааг захиалсан тоо хэмжээгээр цаг хугацаанд нь саадгүй тасралтгүй нийлүүлж, хангахыг шаардах эрхтэй.
- 8.2 Нийлүүлэгчээс бараа нийлүүлэх хугацааг мэдэгдсэнээс хойш ажлын [3] хоногийн дотор бараа хүлээн авах бэлтгэл хангах мөн бараа хүлээн авахдаа тоо хэмжээ чанар байдлыг шалган акт үйлдэн зохих баримтыг бүрдүүлнэ.
- 8.3 Нийлүүлэгдсэн бараа нь ашиглалтын явцад ашиглалтын норм хугацаанд хүрэлгүй шаардлага хангахгүй болсон тохиолдолд хуанлийн 7 хоногт багтаан нийлүүлэгчид мэдэгдэн холбогдох акт баримтыг хүргүүлнэ.

Ес. Талуудын хүлээх хариуцлага

- 9.1 Талуудын эрх, үүрэг нь түүний эрх залгамжлагчид бүрэн хэмжээгээр нэгэн адил хамаарна.
- 9.2 Захиалагчийн удирдлага, бүтэц өөрчлөгдөж солигдсон явдал нь энэхүү гэрээг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
- 9.3 Бараа олгох, хүлээн авах явцад талууд харилцан хянуур, нямбай ажиллаж техникийн болон галын аюулгүйн дүрмийг хатуу баримтлан аливаа осол, гэмтэл, хохирол учруулахаас сэргийлнэ.
- 9.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад учруулсан аливаа хохирлыг буруутай тал нь нэн даруй төлж барагдуулна.
- 9.5 Талууд нь шударга бус өрсөлдөөнөөс болгоомжлох үүднээс энэхүү гэрээ ба түүний хавсралтуудыг нууцлах ба бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

Арав. Давагдашгүй хүчин зүйл

- 10.1 Энэхүү гэрээг байгуулсны дараа давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас аль нэг тал болон талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

- 10.2 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.
- 10.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд харилцан чөлөөлөгдөнө.

Арван нэг. Маргаан шийдвэрлэх.

- 11.1 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.
- 11.2 Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арван хоёр. Бусад зүйл

- 12.1 Энэхүү гэрээг Монгол хэл дээр 3 /гурав/ хувь үйлдсэн бөгөөд хувиуд хууль эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 12.2 Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол улсын иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- 12.3 Энэхүү гэрээг талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 12.4 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	Үнийн хуваарь
Гэрээний ерөнхий нөхцөл	Гэрээний тусгай нөхцөл
Техникийн тодорхойлолт	Бараа нийлүүлэлтийн хуваарь

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

_____ С.Ариунзул
Санхүү Хангамжийн Хэлтсийн дарга

_____ Б. Чинбэлэг
Худалдаа, Хангамжийн Албаны дарга

_____ Н.Энхжаргал
НББА-ны дарга, Ерөнхий нягтлан бодогч

_____ Э.Мандахнаран
Хуулийн зөвлөх
Хаяг: Говьсүмбэр аймаг, Шивээговь сум
42020 Сэвхүүл
Утас: (976)-7054-6464
Факс: (976)-7054-6363

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

_____ Д. Баярсайхан
Захирал

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо,
“НИММ аудит” ХХК-ийн байрны 303 тоотод
Утас: 99112981

№ _____ ТООТ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ
ХАВСРАЛТ № 01 / Үнийн хуваарь/

2023.03.30

Сэвхүүл

ШО/202301027			ОРООМГИЙН БОЛОН ЦАХИЛГААНЫ УТАС			
№	Материалын нэр	Эдийн дугаар	Хэм.нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Цахилгааны утас	ПВЗ ф1,5мм	м	100	1,800	180,000
2	Цахилгааны утас	ПВЗ ф2,5мм	м	100	2,300	230,000
3	Цахилгааны утас	ПВЗ ф4мм	м	100	4,900	490,000
4	Цахилгааны утас	ПВЗ ф6мм	м	100	6,200	620,000
5	Цахилгааны утас	ПВЗ ф10мм	м	100	8,900	890,000
6	Цахилгааны утас	ПВЗ ф16мм	м	100	9,000	900,000
7	Цахилгааны утас	ПВЗ ф25мм	м	100	15,000	1,500,000
8	Ороомгийн утас	ПЭТВ-2 0,85ф	кг	80	125,300	10,024,000
9	Ороомгийн утас	ПЭТВ-2 0,93ф	кг	100	125,300	12,530,000
10	Ороомгийн утас	ПЭТВ-2 1,12ф	кг	80	125,300	10,024,000
11	Ороомгийн утас	ПЭТВ-2 1,25ф	кг	90	131,200	11,808,000
12	Ороомгийн утас	ПЭТВ-2 1,32ф	кг	90	131,200	11,808,000
	ДҮН					61,004,000
	НӨАТ					6,100,400
	НИЙТ ҮНЭ					67,104,400

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

/ _____ /Б. Чинбэлэг/
Худалдаа, хангамжийн албаны дарга

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

/ _____ /Д. Баярсайхан/
Захирал/ _____ Н. Энхжаргал/
НББ Албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч

**ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР**

- Тодорхойлолт
- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.8. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Хоног” гэж хуанлийн хоногийг;
 - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

Тайлбар	1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй /, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
	1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
	1.2.1. ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно;
	1.2.2. бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй;
	1.2.3. зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана;
	1.2.4. ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална;
1.2.5. гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.	
Бараа нийлүүлэх	ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ
	2.1. Нийлүүлэгч нь Гэрээ болон Бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
	2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад тэдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
	2.3. ГЕН-ийн 1.4-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
	2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

Бараа нийлүүлэх газар	2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Барааг хүлээлгэн өгөх	2.6. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, тэмдэглэл үйлдэнэ. 2.7. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
Барааны гарал үүслийн улс	1.8. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.9. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
Баглаа боодол	2.10. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана. 2.11. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд холбогдох хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. 2.12. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
Худалдааны нөхцөл	2.13. Гэрээнд хэрэглэж байгаа Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг ГТН-д заана. 2.14. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр ГЕН-ийн 2.5-д заасан газарт хүргүүлэхнэ.
ГУРАВ. ЗАХИАЛАГЧ	
Барааг хүлээн авах	1.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
Шалгалт, туршилт	3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ. 3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. 3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна. 3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

- | | |
|--------------|---|
| | 3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна. |
| Гэрээний үнэ | 3.7. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана. |
| | 3.8. Гэрээний үнэд тохируулга хийхгүй. |
| Төлбөр төлөх | 3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө. |
| | 3.10. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно. |
| | 3.11. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй. |
| | 3.12. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. |
| | 3.13. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана. |

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

- | | |
|----------------------------|---|
| Захиалагчийн хүлээх эрсдэл | 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна. <ul style="list-style-type: none"> 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан; 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан. |
| Даатгал | 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна. |
| Доголдол | 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ. <ul style="list-style-type: none"> 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй. 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө. 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана. 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана. 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө. |

- | | |
|---|---|
| Чанарын баталгаа | 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө. |
| | 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана. |
| | 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. |
| | 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаа гарган баталгаажуулж болно. |
| | 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаа гаргасан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно. |
| | 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө. |
| | 4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно. |
| Алданги | 4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ. |
| | 4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. |
| Оюуны өмчийн эрх зөрчих | 4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө. |
| | 4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. |
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал | 4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.8-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно. |
| | 4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна. |

- 4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг сунгаж болно.
- Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа 4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.8-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
- 5.1.1. нийлүүлэгч үүргээ гэрээнд заасан хугацаанд, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч Нийлүүлэгч нэмэлт хугацаанд үүрэг гүйцэтгээгүй;
- 5.1.2. бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;
- 5.1.3. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авилгал, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.
- 5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.
- 5.2. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.
- 5.3. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
- Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл 5.4. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- Төлөөлөгч 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажлын болон өөрийн гар

		утасны дугаар, цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.
	6.3.	Гэрээг хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
	6.4.	Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
Нууцлал	6.5.	Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтанд авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
	6.6.	Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
Мэдэгдэл	1.7.	Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
	1.8.	Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.7 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
	1.9.	Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх, эсхүл шуудангаар нөгөө талын гэрээ Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
	1.10.	Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
		1.10.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
		1.10.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор тэмдэглэлийг үндэслэн;
	1.11.	Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
	1.12.	ГЕН-ийн 6.3-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
Маргаан шийдвэрлэх	1.13.	Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
	1.14.	Талууд зөвшилцөн шийдвэрлэж эс чадвал Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гэрээний үүргийн гүйцэтгэл болон гэрээг цуцалсан, гэрээнээс татгалзсантай холбоотой аливаа маргааныг Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	<p>Бараа нийлүүлэх газар:</p> <p><i>[Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, Шивээ Овоо ХК-ийн үйлдвэрлэлийн талбай дахь сэлбэгийн склад]</i></p>
ГЕН 2.6.	<p>Бараа нийлүүлэх хугацаа: <i>[21-30 хоног]</i></p>
ГЕН 2.10.	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <p><i>[Нийлүүлэгч барааг гэрээний тусгай нөхцөлд заасан нөхцөлөөр Шивээ Овоо ХК-ийн үйлдвэрлэлийн талбай дээр үзлэг шалгалт, туршилтыг хийлгэн хүлээлгэн өгч баримт/хүлээлцсэн акт/ үйлдэнэ.</i></p> <p>Бараанд холбогдох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>Барааны гарал үүслийн гэрчилгээ</i> 2. <i>Үйлдвэрлэгчийн баталгаа</i> 3. <i>Үйлдвэрийн болон эрх байгууллагын туршилт тохируулгын гэрчилгээ</i> 4. <i>Нийлүүлэгдэж буй барааны нэр төрөл, тоо хэмжээ, нэгж болон нийт үнийг заасан зарлагын баримт, нэхэмжлэх</i>
ГЕН 2.14.	<p>Баглаа, боодол:</p> <p><i>[Ус чийг нэвтрэхгүй, хайрцаг сав баглаатай байна.]</i></p> <p>Баглаа, боодлын шаардлага:</p> <p><i>[Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна]</i></p>
ГЕН 2.17.	<p>Худалдааны нөхцөл:</p> <p><i>[DDP “Incoterms 2020” Говьсүмбэр аймаг, Шивээговь сум, Шивээ Овоо ХК-ийн үйлдвэрлэлийн талбай дахь сэлбэгийн склад]</i></p>
ГЕН 2.19.	<p>Гүйцэтгэлийн баталгаа:</p> <p><i>Тендерт шалгарсан оролцогч нь ТШЗ-ын 8.5-д заасан гэрээний нөхцлийн дагуу гэрээний үнийн дүнгийн 3%-тай тэнцэх хэмжээний гүйцэтгэлийн баталгааг гарган ирүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааг гарган ирүүлээгүй тохиолдолд гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх болно.</i></p>
ГЕН 3.2	<ol style="list-style-type: none"> 1. <i>Нийлүүлэх барааны шалгалт туршилтыг “Шивээ Овоо” ХК дээр хийж гүйцэтгэнэ.</i> 2. <i>Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.</i> 3. <i>Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин</i>

	<p><i>шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.</i></p> <p>4. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.</p>
ГЕН 3.7	<p>Гэрээний үнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гэрээний валют нь заавал [Монгол төгрөг] байна. 2. Тендерт санал болгосон үнэ тендерийн гэрээ хэрэгжиж дуусгавар болтол хүчин төгөлдөр үйлчилнэ. 3. Гэрээ хэрэгжих явцад гэрээний үнэ өөрчлөгдвөл захиалагч тендерийн гүйцэтгэлийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.
ГЕН 3.9.	<p>Төлбөр төлөх хугацаа:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэгч талд урьчилгаа төлбөр олгохгүй 2. Захиалагч барааг актаар хүлээн авсанаас хойш нэхэмжлэхийн дагуу 12 сарын дотор шилжүүлнэ.
ГЕН 4.2.	<p>Даатгал:</p> <p><i>[Нийлүүлэгч нь барааг тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрдэлээс хамгаалан даатгуулсан байна.]</i></p>
ГЕН 4.3	<p>Доголдол:</p> <ol style="list-style-type: none"> 1. Захиалагч барааг шалгаж илэрсэн зөрчил доголдын талаар нийлүүлэгч талд хуанлийн 7 хоног дотор мэдэгдэнэ. 2. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр нийлүүлэгч уг зөрчил доголдлыг 14-21 хоног дотор өөрийн зардалаар арилгана
ГЕН 4.10.	<p>Баталгаат хугацаа:</p> <p><i>[Баталгаат хугацаа 6 сар байна.]</i></p> <p><i>[Баталгаат хугацаа нь барааг ашиглаж эхэлсэнээс хойш тооцогдоно.]</i></p> <p><i>[Баталгаат хугацаанд ашиглалтын норм хугацаанд хүрэлгүй гарах аливаа асуудлыг нийлүүлэгч 100% бүрэн хариуцна.]</i></p>
ГЕН 4.11	<p>Чанарын баталгаа шаардах эсэх: <i>[Шаардана]</i></p> <p>Чанарын баталгааны дүн:</p> <p><i>[Гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна.]</i></p> <p><i>[Чанарын шаардлага хангахгүй сэлбэг материал нийлүүлсэн тохиолдолд гэрээ цуцлах үндэслэл болно.]</i></p>
ГЕН 4.20	<p>Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ</p>
ГЕН 5.1	<p>Нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй болон гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.</p>

**ШИВЭЭ ОВОО
ХУВЬЦААТ КОМПАНИ**

42020 Сэвхүүл, Шивээговь сум, Говьсүмбэр аймаг,
Утас/Факс: (976) 7054-6464

2023.03.16 № 25/241
танай _____ -ны № _____ -т

**"БАТ ГАЗ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.БАЯРСАЙХАН ТАНАА**

Тус компаниас зарласан ШО/202301027 дугаартай
Ороомгийн болон цахилгааны утас нийлүүлэх
нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтад танай
компанийн ирүүлсэн тендер шалгарсан болно.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр
бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу
гүйцэтгэлийн баталгаа гарган ирж гэрээ байгуулахыг
үүгээр мэдэгдэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.ЭНХТҮВШИН

Барааны үнийн задаргаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс	Тоо хэмжээ э	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ /төг/	Нэг төрөл бүрийн бүгд үнэ (4х6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох тагвар, хураамж (НӨАТ10%)	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх
1	Цахилгааны утас ПВ3 ф1,5мм	ОХУ, БНСУ	100	м	1800	180,000		18,000		Үгүй
2	Цахилгааны утас ПВ3 ф2,5мм		100	м	2300	230,000		23,000		
3	Цахилгааны утас ПВ3 ф4мм		100	м	4900	490,000		49,000		
4	Цахилгааны утас ПВ3 ф6мм		100	м	6200	620,000		62,000		
5	Цахилгааны утас ПВ3 ф10мм		100	м	8900	890,000		89,000		
6	Цахилгааны утас ПВ3 ф16мм		100	м	9000	900,000		90,000		
7	Цахилгааны утас ПВ3 ф25мм		100	м	15000	1,500,000		150,000		
8	Ороомгийн утас ПЭТВ-2 0,85ф	ОХУ, БНХАУ	80	кг	125300	10,024,000		1,002,400		
9	Ороомгийн утас ПЭТВ-2 0,93ф		100	кг	125300	12,530,000		1,253,000		
10	Ороомгийн утас ПЭТВ-2 1,2ф		80	кг	125300	10,024,000		1,002,400		
11	Ороомгийн утас ПЭТВ-2 1,25ф		90	кг	131200	11,808,000		1,180,800		
12	Ороомгийн утас ПЭТВ-2 1,32ф		90	кг	131200	11,808,000		1,180,800		
						61,004,000		6,100,400	67,104,400	
								Тендерийн үнэ:	67,104,400	

Бараа нийлүүлэлтийн хуваарь

№	Барааны нэр		Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	ТӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
						Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа
1	Барааны нэр	Эдийн дугаар	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Бараа хүргэх газрын нэр	Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа	Санал болгож буй хугацаа
1.	Цахилгааны утас	ПВ3 ф1,5мм	100	м	Шивээ -Овоо ХК-ийн сэлбэгийн агуулах	21-30 хоног	30 хоног
2.	Цахилгааны утас	ПВ3 ф2,5мм	100	м			
3.	Цахилгааны утас	ПВ3 ф4мм	100	м			
4.	Цахилгааны утас	ПВ3 ф6мм	100	м			
5.	Цахилгааны утас	ПВ3 ф10мм	100	м			
6.	Цахилгааны утас	ПВ3 ф16мм	100	м			
7.	Цахилгааны утас	ПВ3 ф25мм	100	м			
8.	Ороомгийн утас	ПЭТВ-2 0,85ф	80	кг			
9.	Ороомгийн утас	ПЭТВ-2 0,93ф	100	кг			
10.	Ороомгийн утас	ПЭТВ-2 1,2ф	80	кг			
11.	Ороомгийн утас	ПЭТВ-2 1,25ф	90	кг			
12.	Ороомгийн утас	ПЭТВ-2 1,32ф	90	кг			

Барааг хүргэх эцсийн цэг: Incoterms 2020 DDP

Шивээ -Овоо ХК-ийн сэлбэгийн агуулах

“БАТГАЗ” ХХК-ийн ЗАХИРАЛ



Д.БАЯРСАЙХАН



Энхтайвны өргөн чөлөө 19, Улаанбаатар хот 14210, Монгол улс
И-мэйл: info@tdbm.mn, Вэб: www.tdbm.mn

Утас: (976-11) 312362, 331133
Факс: (976-11) 327028

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА (БАНКНЫ)

Баталгаа хүлээн авагч: **ШИВЭЭ ОВОО ХК**
Огноо: **2023/03/20**
Дугаар: **474DBG/23/01859**
Баталгаа гаргагч: **Худалдаа, Хөгжлийн банк**

1. “БАТГАЗ ХХК” (цаашид “Бараа нийлүүлэгч” гэх) нь “ОРООМГИЙН БОЛОН ЦАХИЛГААНЫ УТАС НИЙЛҮҮЛЭХ ШО/202301027”-ыг худалдан авах зорилгоор “ШО/202301027/01/01” (цаашид “Гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Бараа нийлүүлэгч -ийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **2,100,000 төгрөг**ийн төлбөрийн үүрэг хүлээж
2,100,000 төгрөг
(Хоёр сая нэг зуун мянган төгрөг)-ийн
баталгаа гаргаж байна.
3. Бараа нийлүүлэгч гэрээний үүргээ зөрсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнд ямар нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь **ЗАХИАЛАГЧ АЖИЛ ДУУССАН БАРАА НИЙЛҮҮЛЭГДСЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ /ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ/ ГАРГАСАН ӨДРӨӨС ХОЙШ 28 ХОНОГИЙН ХУГАЦААНД** хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.
6. Энэхүү баталгааг дээд дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрхдлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

Хүндэтгэсэн,

ЧИНГЭЛТЭЙ САЛБАРЫН ЗАХИРАЛ



Банкны баталгааг QR код болон дараах холбоосоор хялбархан баталгаажуулна уу.
<http://www.tdbm.mn/verify.php>
Баталгаажуулах код: 5228E219AEAC8122



Ц.АЛТАНЗАЯА

2201718